



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/27/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2021 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Аудитор: Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд



Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1. Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 297

танай _____ -ны № _____ -т

Г ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.БАЙГАЛМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020276

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	140,578,430.26	202,970,234.33
35	БАРАА МАТЕРИАЛ	140,578,430.26	202,970,234.33
354	Хангамжийн материал	115,459,564.26	175,490,368.33
35420	Аж ахуйн материал	113,359,564.26	90,848,406.13
35430	Сэлбэг хэрэгсэл	2,100,000.00	-
35450	Барилгын засварын материал	-	690,000.00
35460	Хүнсний материал	-	4,747,588.20
35470	Бусад хангамжийн материал	-	79,204,374.00
35600	Мал амьтад	25,118,866.00	27,479,866.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,213,782,503.70	3,099,273,133.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,213,782,503.70	3,099,273,133.82
392	Биет хөрөнгө	3,137,470,503.70	3,023,021,133.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,287,352,081.09	3,287,352,081.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(231,650,996.08)	(433,548,669.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,548,000.00	51,548,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,548,000.00)	(21,297,999.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	174,888,643.00	178,269,355.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(137,339,176.15)	(151,534,980.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,480,270.70	81,920,602.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,032,744.82)	(52,076,580.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,884,600.00	75,884,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,004,600.04)	(4,654,600.08)
39217	Ном	10,892,426.00	11,159,326.00
393	Биет бус хөрөнгө	76,312,000.00	76,252,000.00
39301	Програм хангамж	700,000.00	700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(520,000.00)	(580,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	76,132,000.00	76,132,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	3,354,360,933.96	3,302,243,368.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,354,360,933.96	3,302,243,368.15
51	Засгийн газрын хувь оролцоо	3,354,360,933.96	3,302,243,368.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	536,067,659.92	536,067,659.92
51101	Өмч: - төрийн	536,067,659.92	536,067,659.92
512	Хуримтлагдсан үр дүн	2,088,641,764.73	2,036,524,198.92
51210	Өмнөх үеийн үр дүн	2,088,641,764.73	2,088,641,764.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	(52,117,565.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	729,651,509.31	729,651,509.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	3,354,360,933.96	3,302,243,368.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,357,914,656.51	1,151,618,747.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,343,101,369.51	1,142,518,747.45
120	Нийтлэг татварын бус орлого	9,216,469.51	199,493,397.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,216,469.51	199,493,397.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,035,000.00	-
1200043	Үнэ төлбөргүй авсан Үндсэн хөрөнгө		115,766,683.42
1200044	Үнэ төлбөргүй авсан Бараа материал		81,299,714.07
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,181,469.51	2,427,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,333,884,900.00	943,025,349.96
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	776,485,000.00	922,258,149.96
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	499,699,900.00	-
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	57,700,000.00	20,767,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,813,287.00	9,100,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,813,287.00	9,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,813,287.00	9,100,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,050,742,459.00	1,203,736,313.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,742,459.00	1,203,736,313.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,022,188,275.72	1,152,525,083.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,740,688.00	713,125,072.00
210101	Үндсэн цалин	481,854,463.00	513,778,716.62
210102	Нэмэгдэл	73,170,189.00	146,358,617.38
210104	Урамшуулал	48,716,036.00	52,987,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,414,327.03	89,621,678.10
210201	Тэтгэврийн даатгал	53,160,427.03	57,593,188.96
210202	Тэтгэмжийн даатгал	6,063,600.00	6,796,374.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,850,700.00	4,344,297.03
210204	Ажилгүйдлийн даатгал	1,212,700.00	2,145,977.73
210205	Эрүүд мэндийн даатгал	12,126,900.00	18,741,840.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,149,461.20	49,692,916.26
210301	Гэрэл, шахилгаан	6,546,098.00	8,486,286.06
210302	Түлш, халаалт	47,606,663.20	40,526,630.20
210303	Цэвэр, бохир ус	996,700.00	680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,485,286.19	32,856,680.20
210401	Бичиг хэрэг	920,792.00	638,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,187,527.00	1,376,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	384,917.99	576,850.00
210405	Хог хаягдал зайлгуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	420,000.00	426,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,572,049.20	29,838,950.20
2105	Нормативт зардал	53,506,143.50	25,579,545.40
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	246,700.00	509,273.60
210502	Хоол, хүнс	53,259,443.50	23,045,271.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,025,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,859,100.00	6,527,058.00
210604	Урсгал засвар	7,859,100.00	6,527,058.00
2107	Томилголт, зочны зардал	1,739,000.00	1,173,000.00
210702	Дотоод албан томилголт	1,739,000.00	1,173,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,321,600.00	2,415,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,244,600.00	2,415,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,972,669.80	231,533,943.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	520,000.00	232,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,417,000.00	508,490.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	196,035,669.80	230,792,953.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,554,183.28	51,211,230.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,531,159.00	24,045,592.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,931,159.00	23,530,092.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	515,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,024.28	27,165,638.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,024.28	27,165,638.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	307,172,197.51	(52,117,565.81)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	307,172,197.51	(52,117,565.81)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	848,998,287.00	952,125,349.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	834,185,000.00	943,025,349.96
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	834,185,000.00	943,025,349.96
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	776,485,000.00	922,258,149.96
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	57,700,000.00	20,767,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,813,287.00	9,100,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,813,287.00	9,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,813,287.00	9,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	848,998,287.00	952,125,349.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	848,998,287.00	952,125,349.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,444,103.72	896,174,119.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,490,485.00	713,125,072.00
210101	Үндсэн цалин	481,604,260.00	513,778,716.62
210102	Нэмэгдэл	73,170,189.00	146,358,617.38
210104	Урамшуулал	48,716,036.00	52,987,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,414,327.03	89,621,678.10
210201	Тэтгэврийн даатгал	53,160,427.03	57,553,461.96
210202	Тэтгэмжийн даатгал	6,063,600.00	6,832,362.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,850,700.00	4,340,558.03
210204	Ажилгүйдлийн даатгал	1,212,700.00	2,153,455.73
210205	Эрүүл мэндийн даатгал	12,126,900.00	18,741,840.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,149,461.20	49,692,916.26
210301	Гэрэл, цахилгаан	6,546,098.00	8,486,286.06
210302	Түлш, халаалт	47,606,663.20	40,526,630.20
210303	Цэвэр, бохир ус	996,700.00	680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,636,986.99	7,771,680.00
210401	Бичиг хэрэг	920,792.00	638,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,187,527.00	1,376,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	384,917.99	576,850.00
210404	Ном, хэвлэл	322,400.00	299,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	426,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,401,350.00	4,454,450.00
2105	Нормативт зардал	53,506,143.50	26,112,093.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	246,700.00	509,273.60
210502	Хоол, хувц	53,259,443.50	23,217,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,385,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,769,100.00	5,133,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	910,000.00	-
210604	Урсгал засвар	7,859,100.00	5,133,000.00
2107	Томилголт, зочны зардал	1,739,000.00	1,173,000.00
210702	Дотоод албан томилголт	1,739,000.00	1,173,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,321,600.00	2,415,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,244,600.00	2,415,190.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,417,000.00	1,129,490.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	166,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,417,000.00	962,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,554,183.28	55,951,230.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,531,159.00	28,785,592.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,931,159.00	28,270,092.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	515,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,024.28	27,165,638.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,024.28	27,165,638.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	536,067,659.92	729,651,509.31	2,088,641,764.73	0.00	3,354,360,933.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,067,659.92	729,651,509.31	2,088,641,764.73	0.00	3,354,360,933.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,067,659.92	729,651,509.31	2,088,641,764.73	0.00	3,354,360,933.96
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	536,067,659.92	729,651,509.31	2,088,641,764.73	0.00	3,354,360,933.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,067,659.92	729,651,509.31	2,088,641,764.73	0.00	3,354,360,933.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-52,117,565.81	0.00	-52,117,565.81
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,067,659.92	729,651,509.31	2,036,524,198.92	0.00	3,302,243,368.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	834,185,000.00	834,161,975.72	1,002,229,100.00	915,859,711.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	834,185,000.00	834,161,975.72	1,002,229,100.00	915,859,711.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	805,653,800.00	805,630,816.72	965,630,700.00	887,074,119.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,504,900.00	603,490,485.00	746,401,800.00	713,125,072.00
210101	Үндсэн цалин	461,429,200.00	481,604,260.00	525,400,000.00	513,778,716.62
210102	Нэмэгдэл	79,459,900.00	73,170,189.00	200,960,600.00	146,358,617.38
210104	Урамшуулал	62,615,800.00	48,716,036.00	20,041,200.00	52,987,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,421,200.00	77,414,327.03	93,300,300.00	89,621,678.10
210201	Тэтгэврийн даатгал	53,167,300.00	53,160,427.03	63,444,300.00	57,553,461.96
210202	Тэтгэмжийн даатгал	6,063,600.00	6,063,600.00	5,971,200.00	6,832,362.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,850,700.00	4,850,700.00	1,492,800.00	4,340,558.03
210204	Ажилгүйдлийн даатгал	1,212,700.00	1,212,700.00	7,464,000.00	2,153,455.73
210205	Эрүүл мэндийн даатгал	12,126,900.00	12,126,900.00	14,928,000.00	18,741,840.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,150,000.00	55,149,461.20	57,706,100.00	49,692,916.26
210301	Гэрэл, цахилгаан	6,820,000.00	6,546,098.00	7,502,000.00	8,486,286.06
210302	Тулш, халаалт	46,790,000.00	47,606,663.20	48,664,100.00	40,526,630.20
210303	Цэвэр, бохир ус	1,540,000.00	996,700.00	1,540,000.00	680,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,784,400.00	10,784,399.99	11,270,400.00	6,068,680.00
210401	Бичиг хэрэг	792,400.00	857,792.00	1,728,300.00	638,000.00
210402	Гэвэр, шатахуун	5,595,000.00	5,384,950.00	1,572,100.00	1,376,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,125,000.00	384,917.99	660,000.00	576,850.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	322,400.00	300,000.00	299,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	420,000.00	1,750,000.00	426,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,552,000.00	3,414,340.00	5,260,000.00	2,751,450.00
2105	Нормативт зардал	53,506,300.00	53,506,143.50	41,000,000.00	26,112,093.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	246,700.00	246,700.00	1,500,000.00	509,273.60
210502	Хоол, хүнс	53,259,600.00	53,259,443.50	35,000,000.00	23,217,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	4,500,000.00	2,385,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,550,000.00	2,550,000.00	-	-
210604	Урсгал засвар	2,550,000.00	2,550,000.00	-	-
2107	Томиллот, зочны зардал	812,000.00	811,000.00	760,000.00	713,000.00
210702	Дотоод албан томиллот	812,000.00	811,000.00	760,000.00	713,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,000.00	508,000.00	13,942,100.00	611,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	13,762,100.00	611,190.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	508,000.00	508,000.00	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,417,000.00	1,417,000.00	1,250,000.00	1,129,490.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	250,000.00	166,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,417,000.00	1,417,000.00	1,000,000.00	962,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,531,200.00	28,531,159.00	36,598,400.00	28,785,592.00
2132	Бусад урсгал шилжүүлдэг	28,531,200.00	28,531,159.00	36,598,400.00	28,785,592.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал- үдийн цай	27,931,200.00	27,931,159.00	36,058,400.00	28,270,092.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00	540,000.00	515,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	834,185,000.00	834,161,975.72	1,002,229,100.00	943,025,349.96
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	834,185,000.00	834,161,975.72	1,002,229,100.00	943,025,349.96
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	834,185,000.00	834,161,975.72	1,002,229,100.00	943,025,349.96

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,100,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,100,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,703,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,703,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,133,000.00
210604	Урсгал засвар	5,133,000.00
2107	Томилолт, зочны зардал	460,000.00
210702	Дотоод албан томилолт	460,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,804,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,804,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,100,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,100,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Байгалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сургалтын чанарыг сайжруулж, эрүүл аюулгүй байдалд сурч амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,203,736.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 24,075.0 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,117.5 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	140,578.4	202,970.2	62,391.8
Үндсэн хөрөнгө	3,650,878.0	3,762,966.0	112,088.0
Хуримтлагдсан элэгдэл	(437,095.5)	(663,693.0)	(226,597.5)
Нийт хөрөнгө	3,354,360.9	3,302,243.2	-52,117.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,354,360.9	3,302,243.2	-52,117.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,354,360.9	3,302,243.2	-52,117.7

Бараа материалын дансны үлдэгдэл 202,970.2 мянган төгрөг болж 62,391.8 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн бараа материал худалдан авсан болон хандиваар бараа материал авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,762,966 мянган төгрөг болж 112,088 мянган төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж шилжүүлж авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө акталсан 4,195.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,302,243.3 мянган төгрөг болж 52,117.5 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан болон шилжүүлснээс шалтгаалжээ.

Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 206,296.0 мянган төгрөгөөр буюу 15 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 152,994.0 мянган төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,002,229.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,002,229.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,002,229.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,002,229.1 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 922,258.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,767.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 963,792.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 915,859.7 мянган төгрөгийг зарцуулж 27,165.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 915,859.7 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байна. Үүнээс цалин,нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 802,746.7 мянган төгрөг буюу нийт зардлын 87.6 хувийг эзэлж байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагаанаас 9,100.0 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансаар орж зарцуулалт хийгдсэн байна. Нэмэлт үйл ажиллагааны санхүүжилтийг бичиг хэрэг, аж ахуй, цэвэрлэгээний материал, сурах бичиг авах зардалд зарцуулсан.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт 141 мэдээлэл оруулсан байна. Үүнээс 139 мэдээллийг хугацаандаа оруулж 2 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Батлагдсан төсвийн гүйцэтгэл хэтрэлт хэмнэлтийн 915,859.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж, биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19,605.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19,605.8 мянган төгрөгийн зөрчилд 132.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 19,473.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 19,605.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19,605.8 мянган төгрөгийн зөрчилд 132.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 19,473.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 132.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн

тухай хуул Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 5,581.2 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд гарсан зардлаас 13,891.9 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Худалдан авалтын гэрээний үнийг худалдан авалт хийх бүрд хянахгүй, гэрээний жагсаалтаас өөр нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авч байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Дорнод аймгийн Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДОА-2021/27/СТА-ТШЗ
Шаллагдсан байгууллагын нэр: Дорнод амгийн Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийт 139 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 2 мэдээллийг хугацаа хоцорч оруулсан байна. Үүнд: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр 12 дугаар сард) Батлагдсан төсөв 1,002,229.1 мянган төгрөг ба гүйцэтгэлээр төсөв 915,859.7 мянган төгрөг байна. Мөн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр 11 сард)	0.0	Албан шаардлага өгөх	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Д.Байгалмаа О.Дуламсүрэн
2	Эрдэнэт талын зам ХХК-тай нүүрс тээвэрлэлтийн болон хүнс /мах, сүү/ нийлүүлэх гэрээ байгуулсан байна. Мөн Ольхон ХХК, Дээшлэх нар ХХК, Дорнод хүнс ХХК, Дорнод гурил ХХК болон Дашбалбар Баян-Аят ХХК-тай байгуулсан гэрээнд тусгагдсанаас өөр нэр төрлийн 5,581.2 мянган төгрөгийн хүнс худалдан авсан байна.	5,581.2	Албан шаардлага өгөх	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Д.Байгалмаа О.Дуламсүрэн
3	Харилцахаас нийт 121,364.19 мянган төгрөгийн зардал гарсан бөгөөд төлбөрийн цахим баримттай тулгахад Баян эрхэт улз 1,012.4 мянган төгрөг, ЗОТОЛМӨНХ 169.0 мянган төгрөг, МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО 360.8 мянган төгрөг, НАЙНГИ 1,049.2 мянган төгрөг, ОЛЬХОН 8,829.1 мянган төгрөг, ЦАХИМХИЙЦ 158.0 мянган төгрөг, ЭРДЭНЭТ ТАЛЫН ЗАМ 2,313.4 мянган төгрөгийг тус тус	13,891.9	Албан шаардлага өгөх	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Д.Байгалмаа О.Дуламсүрэн



Дашбалбар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	дутуу илгээсэн бөгөөд нийт 13,891.9 мянган төгрөг и-баримтад шивэгдээгүй байна.				
4	Батлагдсан төсөв 1,572.1 мянган төгрөг, Зарцуулалт хэтрээгүй ч, жишиг нормоор тооцоолоход 132.7 мянган төгрөгийн илүү зарцуулалттай.	132.7	Төлбөрийн акт тогтоох	Сургуулийн захирал Нягтлан бодогч	Д.Байгалмаа О.Дуламсүрэн
ДҮН		19,605.8			